

Сэдэв: Өгүүллэгийн утга, бүтцийн задлал

П. Хорлоо.

АЛТ МӨНГӨ ХОЁР

Эрт цагт нэгэн эцгийн хоёр хүүхэд холын уулнаас мод түүж ирэхээр явж байжээ. Явахад нь ээж нь хоёр хүүдээ замдаа идэж яв гэж нэг нэг боодолтой ааруул эзэгий өгөөд “Хоорондоо эвтэй, ах нь дүүгээ асарч яв” гэж захижээ. Ингээд ах дүү хоёр алсын замд гарчээ.

Энэ хоёр хүүгийн ах нь Алт дүү нь Мөнгө гэдэг нэртэй юм байжээ. Алт, Мөнгө хоёр замдаа их хүйтэн шуургатай шөнө хээр унтах болжээ. Мөнгө нь хэлж гэнэ. “Ах аа, энэ хүйтэн шуургатай шөнө даарна шүү. Хоёулаа хадны агуй олж унтахыг бодъё” гэж хэлэв. Алт нь “Миний дүүгийн хэлдэг зөв. Хоёулаа хоёр тийш явж агуй эрье. Чи энэ уулын өвөр лүү яв. Би уул өөд явья, аль түрүүлж агуй олсон нь бие биенээ дуудъя” гэв. Дүү нь “За тэгье” гэж зөвшөөрөөд хоёр тийшээ салаад хоргодож унтах хадны агуй эрэхээр явцгаажээ.

Мөнгөд хадны агуй ер олдсонгүй. Унтахаар нөмөртэй газар олоод ахыгаа дууджээ. Юу ч дуугарсангүй. Алт нь уулын оройд гараад нэг дулаан агуй олжээ. Хэвтээд үзсэн чинь хоёр хүн арай багтахгүй болохоор би өөрөө дулаан унтвал бусад хүн хамаагүй гэж бодоод дүүгээ дуудсангүй агуйн мухарт орж тавтай унтаж гэнэ.


Мөнгө ахыгаа хэзээ дуудах бол гэж чагнасаар суутал тас харанхуй шөнө болж цасан шуурга улам ширүүсчээ. Өвлийн хүйтэн шуурган дунд нимгэн хөдсөн дээлтэй, Мөнгө хавчигнатал чичирч, айж даарахын эрхэнд ахыгаа олон удаа дуудсан боловч огт чимээ гарсангүй. Мөнгийн гар хуруу чичигнэн хөлдөж үхэх шахаад байтал адуу эрж явсан өвгөн дайралдаж, арваад настай бяцхан Мөнгө хүүг дулаан дээлэндээ хучиж хөлдөж үхэх аюулаас аварчээ.

Тэр ууланд чоно элбэгтэй юм байжээ. Хоёр чоно үдэш агуйгаас босож, шөнө айлуудын хот руу ан хийж яваад юу ч олсонгүй, өлсгөлөндөө гутарсаар үүрлэдэг агуйдаа иртэл агуйд унтаж байгаа бяцхан хүүхдийг хараад тоймгүй баярлаж, хэл амаа долоож идэхээр завдаж, “хэн нь эхлэн барих вэ?” гэж ярилцаж байжээ. Мөнгө хүү өвгөн адуучны хүчээр дааралгүй хоносон боловч ахыгаа харанхуйд төөрөөд хөлдөж үхсэн болов уу гэж бодсоор байгаад үүрийн цагаан гэгээгээр босож ахыгаа эрсээр хадны агуйн дэргэд ирээд агуй руу мөлхөж яваа хоёр чоныг үзээд чанга дуугаар хашгиртал цогтой хүүгийн дуугаар чоно зугтаад явчихав. Алт арай гэж сэрээд чонын барааг хараад уушиг зүрх нь дэлбэрэх шахжээ. Ингээд ах дүү Алт, Мөнгө хоёр үүрээр уулзжээ.

1. Дээрх өгүүллэг дэх үгсийн утгыг тайлбарлаарай.

- | | |
|----------------|---|
| 1. Эзэгий | a) Сүлд жавхаатай, сэргэлэн цовоо |
| 2. Агуй | b) Уул хаданд тогтсон орж, гарах амтай том хөндий нүх, хонгил |
| 3. Хөдсөн дээл | c) Сүүг ээдүүлж, буцалган, ширгээсэн идээ |
| 4. цогтой | d) Элдсэн арьсаар хийсэн хуучирсан дээл |

2. Зохиолын өгүүлэгдэхүүн бүтэц ба үйл явдлын хамаарлыг зураг дээр нөхөж харуулаарай.



- A. Мод түүхээр явахад үед ээж нь “ Хоорондоо эвтэй, ах нь дүүгээ асарч яваарай” гэж хоёр хоёр хүүдээ захиад, алсын замд үджээ.
- B. Алт, мөнгө хоёр замдаа хүйтэн шуургатай шөнө хээр унтах болжээ. Хоёулаа даарахгүйн тулд хоёр тийшээ явж, агуй эрэхээр салан явлаа.
- C. Ах Алт нь агуй олоод хоёр хүн багтахгүй учир “Би л өөрөө дулаан унтаж байвал бусад нь хамаагүй” гэж бодоод унтав.
- D. Дүү нь ахыгаа дуудах байх гэж чагнасаар хөлдөж үхэхийн даваан дээр нэгэн адуучин өвгөн таарч, хөлдөж үхэх аюулаас аварчээ.
- E. Хоёр чоно шөнө анд яваад, үүрлэдэг агуйдаа иртэл бяцхан хүү унтаж байхыг хараад идэхийг завдав.
- F. Мөнгө хүү ахыгаа хайж яваад хоёр чонотой таарж, хашхирсанд, чонод зугтаачхав.
- G. Алт сэрж, чонын барааг хараад айжээ.
- H. Ингэж ах дүү хоёр үүрээр уулзжээ.

3. Зохиолч хоёр хүүгийн өөр өөр зан төрхийг харуулахын тулд цаг хугацааны хувьд, орон байрлалын хувьд ямар орчныг сонгож авсан бэ?

- A. Зуны дулаан, бороотой өдөр ойд
- B. Намрын хүйтэн, шуургатай өдөр, ууланд
- C. Өвлийн хүйтэн, шуургатай шөнө ууланд
- D. Хаврын хүйтэн хавсаргатай, шөнө ууланд

4. Зохиолчийн сонгосон уг орчинд хоёр хүү юу юу хийсэн бэ?

1. Алт	A. Дулаан агуй олсон. Нэгийгээ дуудаагүй. Агуйд тавтай унтсан. Чоно хараад айсан.
2. Мөнгө	B. Нөмөртэй газар олоод нэгийгээ дуудсан. Ахдаа санаа нь зовсон. Ахыгаа хайсан.

5. Зохиолчийн сонгосон цаг хугацаа, орон газарт Алт, Мөнгө хоёрын зан төрхийн ямар ямар онцлог илэрсэн бэ?

- A. Ах Алт нь аминчхан, хүний мөсөөр тааруу, аймхай бол Мөнгө нь итгэмтгий, сайхан сэтгэлтэй, сэргэлэн. Өөрөөр хэлбэл зохиолч энэ хоёрын эсрэг тэсрэг хоёр өөр зан төрхийг харуулсан.
- B. Хоёр хүүгийн нэг нэгнээ гэсэн халуун дулаан сэтгэл, сэргэлэн цовоо байдлыг харуулсан. Өөрөөр хэлбэл төрсөн ах дүү нарын зан төрхийн ижил шинжийг харуулсан.
- C. Дүү Мөнгө нь аминчхан, хүний мөсөөр тааруу, аймхай бол ах Алт нь итгэмтгий, сайхан сэтгэлтэй, сэргэлэн. Өөрөөр хэлбэл зохиолч энэ хоёрын эсрэг тэсрэг хоёр өөр зан төрхийг харуулсан.

6. Хоёр хүүгийн зорилгыг чухлаар нь эрэмбэлээрэй.

- A. Эвтэй, найртай байх
- B. Мод түүх
- C. Шөнө дааралгүй дулаан хонох

7. Том ах нь эвтэй, найртай байх зорилгоо биелүүлж чадсан уу?

- A. Тийм
- B. Үгүй

8. Дээрх өгүүллэгт юуны тухай (сэдэв) өгүүлсэн бэ?
- A. Ажил хөдөлмөрийн тухай
 - B. Ах дүү хоёрын тухай
 - C. Ээжийн сургаалын тухай
 - D. Хүний мөс чанарын тухай
9. Зохиолч уг өгүүллэгт амиа бодсон, сэтгэл муутай Алт чонотой таарч байхад, ахыгаа боддог, ээжийнхээ захиасыг дагадаг, сэтгэл сайтай хүү Мөнгө адуучин хүнтэй таарч байгаагаар дүрсэлснээрээ уншигчдад юуг харуулахыг хүссэн бэ?
- A. Сайн санааны үзүүрт тос, муу санааны үзүүрт цус гэдгийг ойлгуулахыг хүссэн.
 - B. Эвт шаазгай буга барина гэсэн санааг ойлгуулахыг хүссэн.
 - C. Дуугарвал дуу нэг, дугтарвал хүч нэгтэй байхыг уриалахыг хүссэн.
 - D. Сайныг дагавал сарны гэрэл, мууг дагавал могойн хорлол болдгийг ойлгуулахыг хүссэн.
10. Дараах эшлэлд ямар дүрслэх ур маяг хэрэглэсэн байна вэ? Тодруулсан үгсийг маш анхааралтай ажиглана уу.

*Хоёр чоно үдэш агуйгаас босож, шөнө айлуудын хот руу ан хийж яваад юу ч олсонгүй, өлсгөөлдөө **гутарсаар** үүрлэдэг агуйдаа иртэл агуйд унтаж байгаа бяцхан хүүхдийг хараад **тоймгүй баярлаж**, хэл амаа долоож идэхээр завдаж, “**хэн нь эхлэн барих вэ?**” гэж ярилцаж байжээ.*

- A. Амьдчилал
- B. Хэтрүүлэл
- C. Хүншүүлэл
- D. Тойруулал